



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/88

Дуурсах

Сургалт зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил” А/136 дугаар тушаал, Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.9.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эм зүйч, эм найруулагч нарын оролцоог нэмэгдүүлж, чадавхжуулах” сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Эм зүйч, эм найруулагч нарын оролцоог нэмэгдүүлж, чадавхжуулах” сургалтын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтад зарцуулагдах 1.120,000 (Нэг сая нэг зуун хорин мянган) төгрөгийг бараа ажил үйлчилгээний бусад зардалаас гаргахыг ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох санхүүгийн анхан шатны бичиг баримтыг бүрэн гүйцэт хүлээлгэн өгөхийг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (С.Дуламсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагва-Очир)-т даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ



642201360

Эрүүл мэндийн газрын оны
...10... дугаар сарын 20... -ны өдрийн
А.Д.Д. Дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭМ ЗҮЙЧ, ЭМ НАЙРУУЛАГЧ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ,
ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Үндэслэл: Үйлчлүүлэгчийн оролцоотой чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэх нь манай улсын төдийгүй дэлхий нийтийн эрүүл мэндийн байгууллагуудын эрхэм зорилго юм.

Иймд 2022 оныг Эрүүл мэндийн яамнаас “**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил**” болгон зарласантай холбогдуулан эм зүйн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй аюулгүй хүргэх эмийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Зорилго: Эм зүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, эмийн аюулгүй байдал эмийн мэргэжилтэн нарын мэдлэг, багаар ажиллах чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хамрагдах хүрээ: Сургалтанд сумдын эмийн сангийн эрхлэгч нар, хувийн хэвшлийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын эрхлэгч нарыг хамруулна.

Хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдөр 09:00 цагт Эрүүл мэндийн газрын зааланд

Үйл ажиллагааны чиглэл:

1. Эм зүйн тусламж үйлчилгээг чанартай аюулгүй, хүртээмжтэй хүргэхэд эм зүйч, эм найруулагч нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, арга зүйн зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.
2. Эмийн хяналтын талаар батлагдсан хууль тогтоожийг таниулах, мэдээлэл өгөх.

Үр дүн:

1. Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, эмийн мэргэжилтнүүдийн мэдлэг дээшилсэн байна.
2. Хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.
3. Архив бичиг хэрэг хөтлөлтийн стандарт сайжирна.

_____ оОо _____

Эрүүл мэндийн газрын 2022 оны
 ...10... дугаар сарын 20 -ны өдрийн
 А.88... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭМ ЗҮЙЧ, ЭМ НАЙРУУЛАГЧ НАРЫГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ,
 ЧАДАВХЖУУЛАХ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 09:00 – 17:30 цаг

Хаана: Эрүүл мэндийн газар сургалтын танхимд

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах албан тушаалтан
1	2	3
2022.10.21-ны өдрийн сургалтын чиглүүлэгч ЭТХ мэргэжилтэн С.Дуламсүрэн		
08.30-09.00	Бүртгэл	Эмнэлгийн тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Ө.Заяа
09.00-09.20	Нээлт	Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргал
09.20-10.00	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал талаарх мэдээлэл	ЭЭХХЗГ-ын улсын байцаагч А.Энхзаяа
10.00-10.40	Хүний нөөцийн бүртгэл hr.burtgel.	Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Батдэлгэр
10.40-11.20	Эм зүйн салбарын үзүүлэлт	Эм, эмнэлгийн хэрэгсэл чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн С.Дуламсүрэн
11.20-11.40 Цайны завсарлага		
11.40-12.30	Архив бичиг хэрэг хөтлөлтийн стандарт	Архив бичиг хэргийн эрхлэгч На.Эрдэнэчимэг
12.30-13.00	Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны чиг үүрэг, холбогдох эрх зүйн баримт бичгийн мэдээлэл	Ёс зүйн салбар хороо
13.00-14.00 Өдрийн хоол		
14.00-15.00	Эмийн сангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох	“Энх-тун” эмийн сантай танилцах
15.00-15.30	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн мэдээлэл	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн санар төлбөрийн мэргэжилтэн В.Нарантуяа
15.30-16.00	Тусгай зөвшөөрлийн чиг үүрэг, хуулийн мэдээлэл	О.Найгалмаа
16.00-16.20 Цайны завсарлага		
16.20-17.30	Дүгнэлт, ярилцлага, Гэрээний хэрэгжилт, хаалт	Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргал
17.30	Дурсгалын зураг авхуулах	

Эрүүл мэндийн газрын 2022 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн
А.38 Дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**ЭМ ЗҮЙЧ, ЭМ НАЙРУУЛАГЧ НАРЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тооцоолол	Мөнгөн дүн
1. Оролцогчдын зардал					
1	Оролцогчдын өдрийн хоолны зардал	9.000 төг	45	45*9.000	405.000
2	Цайны зардал	5.000 төг	45	45*5000*2 өдөр	450.000
2. Сургалтын хэрэглэгдэхүүний зардал					
3	Сургалтын гарын авлага, бичиг хэрэг	5.000 төг	45	45*5.000	225.000
4	Сургалтын самбар хөл	40.000 төг	180*80 МКВ	40.000	40.000
	Нийт дүн				1.120.000

_____ ооо _____